

**БАНКУУДЫН ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ**  
**(2024 оны II улирлын түүвэр судалгааны тайлан)**

**Судалгааны товч үр дүн**

Банкуудаас 2024 оны 7 дугаар сарын 1-9-ний өдрийн хооронд санал асуулга хэлбэрээр өнгөрсөн болон ирэх 3 сарын хугацааны зээлийн шалгуур, нөхцөл, эрэлт, нийлүүлэлтийн талаарх мэдээллийг цуглуулан нэгтгэж, тайлан боловсруулав. Үр дүнг товч танилцуулбал:

**Зээлийн шалгуур**

- Өнгөрсөн 3 сарын хугацаанд том банкууд иргэдийн зээлийн шалгууртаа өөрчлөлт оруулаагүй бол ААН-ийн зээлийн шалгуураа бага зэрэг сулруулжээ. Харин дунд болон жижиг банкууд зээлийн шалгууртаа өөрчлөлт оруулаагүй байна.
- Ирэх 3 сарын хугацаанд хугацаанд том банкууд ААН-ийн, дунд банкууд иргэдийн зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулах, бусад зээлийн шалгуураа хэвээр хадгалах төлөвтэй байгаа бол жижиг банкууд зээлийн шалгуураа хэвээр нь хадгалах хандлагатай байна.

**Зээлийн нөхцөл**

- Өнгөрсөн 3 сарын хугацаанд банкууд ААН, иргэдийн зээлийн нөхцөлдөө өөрчлөлт оруулаагүй байна.
- Ирэх 3 сарын хугацаанд банкууд зээлийн нөхцөлөө хэвээр хадгалах хүлээлттэй байна.

**Зээлийн эрэлт**

- Өнгөрсөн 3 сарын хугацаанд том банкуудын зээлийн эрэлт бага зэрэг нэмэгджээ. Харин дунд болон жижиг банкуудын зээлийн эрэлтэд өөрчлөлт ороогүй байна.
- Ирэх 3 сард том банкуудын зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байгаа бол дунд болон жижиг банкууд зээлийн эрэлт өөрчлөгдөхгүй гэж үзэж байна.

**Зээлийн нийлүүлэлт**

- Ирэх 3 сард том банкууд ААН-ийн зээлийн нийлүүлэлтээ бага зэрэг, иргэдийн зээлийн нийлүүлэлтээ нэлээд нэмэгдүүлэх төлөвтэй байна. Харин дунд болон жижиг банкууд зээлийн нийлүүлэлтээ хэвээр хадгалах хандлагатай байна.

**Хүснэгт 1.1 Судалгааны нэгдсэн үр дүн**

Банкууд / Зээлийн төлөв	Зээлийн шалгуур		Зээлийн нөхцөл		Зээлийн эрэлт		Зээлийн нийлүүлэлт	
	ААН	Иргэд	ААН	Иргэд	ААН	Иргэд	ААН	Иргэд
Өнгөрсөн 3 сарын хугацаанд								
Том	↓	0	0	0	↑	↑		
Дунд	0	0	0	0	0	0		
Жижиг	0	0	0	0	0	0		
Ирэх 3 сарын хугацаанд								
Том	↑	0	0	0	↑	↑	↑	↑↑
Дунд	0	↑	0	0	0	0	0	0
Жижиг	0	0	0	0	0	0	0	0

Тэмдэглэл: ↑ бага зэрэг чангарах/нэмэгдэх; ↑↑ нэлээд чангарах/нэмэгдэх; 0 өөрчлөгдөөгүй; ↓ бага зэрэг сулрах/буурах; ↓↓ нэлээд сулрах/буурах

## Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь банкуудаас олгож буй зээлийн шалгуур, нөхцөл, эрэлт болон нийлүүлэлт, тэдгээрийн цаашдын төлөвийг тодорхойлоход оршино.

## Судалгааны хамрах хүрээ

Банкны зээлийн төлөвийн судалгаанд нийт 12 банкиг хамруулсан бөгөөд тухайн банкны зээлийн үйл ажиллагаа хариуцсан шийдвэр гаргах түвшний удирдах албан тушаалтнуудаас асуулга авсан болно.

## Арга зүйн товч тайлбар

Банкны зээлийн төлөвийн судалгааг санал асуулга хэлбэрээр зохион байгуулдаг бөгөөд (i) зээлийн шалгуур, (ii) зээлийн нөхцөл, (iii) зээлийн эрэлт болон (iv) зээлийн нийлүүлэлт гэсэн 4 үндсэн хэсгээс бүрдэнэ. Судалгааны үр дүнг нэгтгэхдээ банкуудын чанарын хариултуудыг нэг утгатайгаар тодорхойлохын тулд тоон утга руу хөрвүүлсэн. Ингэхдээ [-1;+1] хоорондох утгуудад чанарын асуултуудыг Хүснэгт 1.2-т өгөгдсөн байдлаар индексэд хөрвүүлдэг.

Хүснэгт 1.2 Индексийн тооцоолол					
Индексийн утга	-1.0	-0.5	0	0.5	1.0
Зээлийн шалгуур	Нэлээд суларсан/суларна	Бага зэрэг суларсан/суларна	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг чангарсан/чангарна	Нэлээд чангарсан/чангарна
Зээлийн нөхцөл	Нэлээд суларсан/суларна	Бага зэрэг суларсан/суларна	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг чангарсан/чангарна	Нэлээд чангарсан/чангарна
Зээлийн эрэлт	Нэлээд багассан/багасна	Бага зэрэг багассан/багасна	Өөрчлөгдөөгүй	Бага зэрэг нэмэгдсэн/нэмэгдэнэ	Нэлээд нэмэгдсэн/нэмэгдэнэ
Зээлийн нийлүүлэлт	Нэлээд бууруулна	Бага зэрэг бууруулна	Өөрчлөхгүй	Бага зэрэг нэмэгдүүлнэ	Нэлээд нэмэгдүүлнэ


Нийт банкны системийн зээлийн төлөвийг тодорхойлохдоо банк тус бүрийн зээлийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээг тухайн банкны харгалзах индексээр үржүүлэх замаар жигнэсэн дундаж утгыг тооцсон болно. Тухайн хугацаан дахь ерөнхий индексийн утга нь зээлийн шалгуур, нөхцөл, эрэлт, нийлүүлэлтийн талаарх өнгөрсөн 3 сарын байдал болон ирэх 3 сарын төлөвийг илэрхийлнэ.

# I. Зээлийн шалгуур

## 1.1 Аж ахуйн нэгжийн зээлийн шалгуур

- Банкуудын ААН-ийн зээлийн шалгуур 2018 оноос хойш харьцангуй тогтвортой байсан бол 2021 оны I улирлаас эхлэн 4 улирлын турш сулрах мужид байжээ. Харин банкууд 2022 онд зээлийн шалгуураа нэлээд чангаруулсан бол 2023 оны I улирлаас сулруулж эхэлсэн байна. 2024 оны II улиралд ААН-ийн зээлийн шалгуурын индекс -0.18 утгатай гарч, зээлийн шалгуур бага зэрэг суларсан байна. Ирэх улиралд банкууд ААН-ийн зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулах төлөвтэй байна (Зураг 1).

**Зураг 1. ААН-ийн зээлийн шалгуур ба хүлээлт**




- Банкууд 2024 оны II улиралд ХАА, боловсруулах үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбарт олгох зээлийн шалгуурыг бага зэрэг сулруулсан бол уул уурхай, барилгын салбарын зээлийн шалгууртаа өөрчлөлт оруулаагүй байна. 2024 оны III улиралд ХАА-н зээлийн шалгуурыг сулруулах, бусад салбарт хэвээр нь хадгалах төлөвтэй байна (Хүснэгт 1).

**Хүснэгт 1. ААН-ийн зээлийн шалгуур, салбараар**

Хугацаа	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
2024.II улирлын хүлээлт	0	-0.24	0.09	0	0.22	-0.15
2024.II улирлын үр дүн	-0.18	-0.23	0	-0.18	0	-0.17
2024.III улирлын хүлээлт	0.17	-0.22	0	0	0	0

- 2024 оны II улиралд ААН-ийн зээлийн шалгуурыг сулруулахад эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал болон эх үүсвэрийн зардал буурсан нь гол нөлөөг үзүүлжээ (Зураг 2).


**Зураг 2. ААН-ийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс**



## 1.2 Иргэдийн зээлийн шалгуур

- Банкуудын иргэдийн зээлийн шалгуур 2020-2021 онд харьцангуй тогтвортой байжээ. Харин банкууд 2022 онд зээлийн шалгуураа чангаруулж, 2023 оны I улирлаас сулруулж эхэлсэн бол оны сүүлээр эргээд бага зэрэг чангаруулсан байна. 2024 оны II улиралд иргэдийн зээлийн шалгуурын индекс -0.07 гарсан бөгөөд банкууд зээлийн шалгуураа бага зэрэг сулруулжээ. Ирэх улиралд банкууд иргэдийн зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулах төлөвтэй байна (Зураг 3).

**Зураг 3. Иргэдийн зээлийн шалгуур ба хүлээлт**




- Банкууд 2024 оны II улиралд малчны, тэтгэврийн зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулж, бизнесийн, хэрэглээний зээлийн шалгуураа бага зэрэг сулруулсан бол цалин, автомашины зээлийн шалгууртаа өөрчлөлт оруулаагүй байна. Ирэх улиралд бизнесийн зээлийн шалгуурыг сулруулах, бусад төрлийн зээлийн шалгуурыг бага зэрэг чангаруулах төлөвтэй байна (Хүснэгт 2).

**Хүснэгт 2. Иргэдийн зээлийн шалгуур, зээлийн ангиллаар**

Хугацаа	Нийт зээл	Цалин-гийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашины зээл
2024. II улирлын хүлээлт	-0.09	0.21	0	0	0	-0.07	-0.21
2024. II улирлын үр дүн	-0.07	0	0.09	-0.15	-0.28	0.50	0
2024. III улирлын хүлээлт	0.13	0.10	0.11	0.17	-0.27	0.28	0.09

- 2024 оны II улиралд иргэдийн зээлийн шалгуурыг сулруулахад нөлөөлсөн хүчин зүйлсийг авч үзвэл өрсөлдөөн нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ (Зураг 4).

**Зураг 4. Иргэдийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс**




## II. Зээлийн нөхцөл

### 2.1 Аж ахуйн нэгжийн зээлийн нөхцөл

- Банкуудын ААН-ийн зээлийн нөхцөл 2018 оноос хойш харьцангуй тогтвортой байсан бол 2021 онд огцом суларч, чиглэлийн индексийн утга нь 5 улирлын турш сулрах мужид байжээ. Харин 2022 онд бага зэрэг чангарч, 2023 онд харьцангуй тогтвортой байсан бол 2024 он гарсаар бага зэрэг суларсан байна. Банкууд ААН-ийн зээлийн нөхцөлөө сүүлийн 2 улирал дараалан сулруулсан бөгөөд ирэх улиралд зээлийн нөхцөлөө хэвээр хадгалах төлөвтэй байна (Зураг 5).

**Зураг 5. ААН-ийн зээлийн ерөнхий нөхцөл ба хүлээлт**




- Банкууд 2024 оны II улиралд ХАА, боловсруулах үйлдвэр, барилгын салбарт олгох зээлийн нөхцөлөө бага зэрэг сулруулсан бол уул уурхай, худалдаа, үйлчилгээний салбарт олгох зээлийн нөхцөлөө өөрчлөөгүй байна (Хүснэгт 3).

**Хүснэгт 3. ААН-ийн зээлийн ерөнхий нөхцөл, салбараар**

Хугацаа	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
2024.I улирлын үр дүн	-0.05	-0.10	0	0	0	-0.08
2024.II улирлын үр дүн	-0.10	-0.13	0	-0.08	-0.08	0

- 2024 оны II улиралд банкууд ААН-ийн зээлийн хүүг бууруулах, хугацааг уртасгах, хүүний бус шимтгэлийг бууруулах зэргээр зээлийн нөхцөлөө сулруулжээ (Зураг 6).

**Зураг 6. ААН-ийн зээлийн нөхцөлүүд**



- Хүснэгт 4-т банкуудаас ААН-д тухайн улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХүү), жигнэсэн дундаж хугацаа (ЖДХугацаа) болон шинээр олгосон зээлийн хэмжээг түүвэр судалгааны үр дүнд гарсан зээлийн хүү, хугацаа, хэмжээний индекстэй харьцуулан эдийн засгийн салбаруудаар харуулав. 2024 оны II улиралд ХАА, боловсруулах үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбарт олгосон зээлийн ЖДХүү өмнөх улирлаас буурсан бөгөөд энэ нь түүвэр судалгааны үр дүнтэй нийцтэй гарсан байна. Уул уурхай, барилгын салбарт олгосон зээлийн ЖДХүү өмнөх улирлаас төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд энэ нь түүвэр судалгааны үр дүнтэй ерөнхийдөө нийцтэй байна. Нийт салбаруудад олгосон зээлийн ЖДХугацаа уртассан бол түүвэр судалгаагаар банкууд нийт салбаруудад олгосон зээлийн хугацаанд өөрчлөлт оруулаагүй гэж хариулсан байна. 2024 оны II улиралд нийт салбаруудад шинээр олгосон зээлийн хэмжээ нэмэгдсэн бол банкууд нийт салбаруудад олгосон зээлийн хэмжээний нөхцөлийг сулруулсан гэж хариулсан түүвэр судалгааны үр дүнтэй нийцтэй гарсан байна.


<b>Хүснэгт 4. ААН-д олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү болон хугацаа, салбараар</b>						
Зээлийн нөхцөлүүд	Хугацаа	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
Банкуудын зээлийн ЖДХүү (%)	- 2024.I улирал	11.8	16.3	16.5	17.6	17.0
	- 2024.II улирал	7.1	16.0	14.1	17.5	16.3
	- Өөрчлөлт (%)	<u>-4.7</u>	<u>-0.3</u>	<u>-2.4</u>	<u>-0.1</u>	<u>-0.7</u>
Зээлийн хүүний нөхцөл (судалгааны үр дүн)	2024.II улирал	-0.23	0	-0.18	0	-0.17
Банкуудын зээлийн ЖДХугацаа (сар)	- 2024.I улирал	28.2	29.4	21.7	25.2	40.8
	- 2024.II улирал	54.9	35.0	42.8	33.8	41.3
	- Өөрчлөлт (сар)	<u>+26.7</u>	<u>+5.6</u>	<u>+21.1</u>	<u>+8.6</u>	<u>+0.5</u>
Зээлийн хугацааны нөхцөл* (судалгааны үр дүн)	2024.II улирал	0	0	0	0	0
Банкуудын шинээр олгосон зээлийн хэмжээ (тэрбум төг.)	- 2024.I улирал	47.7	594.6	563.7	361.5	4,896.8
	- 2024.II улирал	425.8	941.7	977.4	869.8	6,416.9
	- Өөрчлөлт (%)	<u>+896</u>	<u>+58</u>	<u>+73</u>	<u>+141</u>	<u>+31</u>
Зээлийн хэмжээний нөхцөл* (судалгааны үр дүн)	2024.II улирал	-0.23	-0.08	-0.01	-0.21	-0.01

\*-Зээлийн хугацаа, хэмжээний нөхцөл (-) утгатай бол нөхцөлийг сулруулсан буюу зээлийн хугацаа уртасч, зээлийн хэмжээ нэмэгдсэнийг илэрхийлнэ. (+) утгатай бол нөхцөлийг чангаруулсан буюу зээлийн хугацаа богиносч, зээлийн хэмжээ буурсныг илэрхийлнэ.

## 2.2 Иргэдийн зээлийн нөхцөл

- Банкууд иргэдийн зээлийн нөхцөлөө 2021 оны I улирлаас эхлэн сулруулж байсан бол 2022 оны II улирлаас эхлэн чангаруулж, 2023 оны эхнээс бага зэрэг сулруулжээ. 2024 оны эхний 2 улиралд банкууд иргэдийн зээлийн нөхцөлөө бага зэрэг сулруулсан бөгөөд 2024 оны III улиралд мөн адил бага зэрэг сулруулах төлөвтэй байна (Зураг 7).

**Зураг 7. Иргэдийн зээлийн ерөнхий нөхцөл ба хүлээлт**




- Банкууд 2024 оны I улиралд малчны зээлээс бусад төрлийн зээлийн нөхцөлөө бага зэрэг сулруулж байсан бол 2024 оны II улиралд хэрэглээ, малчин болон тэтгэврийн зээлийн нөхцөлийг бага зэрэг сулруулж, бизнесийн зээлийн нөхцөлийг бага зэрэг чангаруулсан бол цалин, автомашины зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулаагүй байна (Хүснэгт 5).

**Хүснэгт 5. Иргэдийн зээлийн ерөнхий нөхцөл, зээлийн төрлөөр**

Хугацаа	Нийт зээл	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашины зээл
2024.I улирлын үр дүн	-0.09	-0.09	-0.03	-0.05	-0.10	0.05	-0.04
2024.II улирлын үр дүн	0	0	-0.03	-0.11	0.04	-0.06	0

- 2024 оны II улиралд банкууд иргэдэд олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, барьцаа хөрөнгийн шаардлагыг бууруулах зэргээр зээлийн нөхцөлөө сулруулжээ (Зураг 8).

**Зураг 8. Иргэдийн зээлийн нөхцөлүүд**



- Хүснэгт 6-д банкуудаас иргэдэд тухайн улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХүү), жигнэсэн дундаж хугацаа (ЖДХугацаа) болон шинээр олгосон зээлийн хэмжээг түүвэр судалгааны үр дүнд гарсан зээлийн хүү, хугацаа, хэмжээний индекстэй харьцуулан зээлийн төрлөөр харуулав. 2024 оны II улиралд цалин, тэтгэвэр, малчны зээлийн ЖДХүү өмнөх улирлаас төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд энэ нь түүвэр судалгааны үр дүнтэй ерөнхийдөө нийцтэй байна. Харин хэрэглээний зээлийн ЖДХүү 0.5%-аар буурсан бол, автомашины зээлийн ЖДХүү 0.6%-аар нэмэгджээ. Цалин, тэтгэврийн зээлээс бусад төрлийн зээлийн ЖДХугацаа 0.6-2.9 сараар буурсан бол түүвэр судалгаагаар бүх төрлийн зээлийн хугацааг хэвэндээ байсан гэж хариулжээ. 2024 оны II улиралд иргэдэд шинээр олгосон хэрэглээний болон автомашины зээлийн хэмжээ нэмэгдсэн нь түүвэр судалгааны үр дүнтэй нийцтэй гарсан байна. Харин цалин, тэтгэвэр, малчны зээлийн хувьд түүвэр судалгааны зээлийн хэмжээний индекстэй харьцуулахад эсрэг үр дүн гарчээ.

<b>Хүснэгт 6. Иргэдэд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү болон хугацаа, салбараар</b>						
Зээлийн нөхцөлүүд	Хугацаа	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Малчны зээл	Автомашины зээл
Банкуудын зээлийн ЖДХүү (%)	- 2024.I улирал	17.5	15.8	22.6	20.3	18.7
	- 2024.II улирал	17.6	15.8	22.1	20.2	19.3
	- Өөрчлөлт (%)	<u>+0.1</u>	<u>0</u>	<u>-0.5</u>	<u>-0.1</u>	<u>+0.6</u>
Зээлийн хүүний нөхцөл (судалгааны үр дүн)	2024.II улирал	0	0	0	0	0
Банкуудын зээлийн ЖДХугацаа (сар)	- 2024.I улирал	28.5	13.6	31.9	24.2	29.6
	- 2024.II улирал	29.0	14.0	31.0	23.6	26.7
	- Өөрчлөлт (сар)	<u>+0.5</u>	<u>+0.4</u>	<u>-0.9</u>	<u>-0.6</u>	<u>-2.9</u>
Зээлийн хугацааны нөхцөл* (судалгааны үр дүн)	2024.II улирал	0	0	0	0	0
Банкуудын шинээр олгосон зээлийн хэмжээ (тэрбум төг.)	- 2024.I улирал	1,427.5	807.7	115.1	333.6	24.9
	- 2024.II улирал	2,224.4	736.1	155.9	217.5	26.5
	- Өөрчлөлт (%)	<u>+56</u>	<u>-9</u>	<u>+35</u>	<u>-35</u>	<u>+6</u>
Зээлийн хэмжээний нөхцөл* (судалгааны үр дүн)	2024.II улирал	0	0	-0.01	0.22	-0.01

\*-Зээлийн хугацаа, хэмжээний нөхцөл (-) утгатай бол нөхцөлийг сулруулсан буюу зээлийн хугацаа уртасч, зээлийн хэмжээ нэмэгдсэнийг илэрхийлнэ. (+) утгатай бол нөхцөлийг чангаруулсан буюу зээлийн хугацаа богиносч, зээлийн хэмжээ буурсныг илэрхийлнэ.




### Ш. Зээлийн эрэлт

#### 3.1 Аж ахуйн нэгжийн зээлийн эрэлт

- ААН-ийн зээлийн эрэлт 2020 оны I, II улирлыг эс тооцвол 2018 оноос өнөөг хүртэл өндөр хэвээр байна. 2024 оны II улиралд ААН-ийн зээлийн эрэлт нэлээд нэмэгдсэн нь өмнөх улирлын хүлээлтийн хандлагатай нийцтэй гарчээ. Ирэх улиралд ААН-ийн зээлийн эрэлт мөн өндөр хэвээр байх хэдий ч өмнөх улирлын хүлээлтийн утгаас бага зэрэг буурах төлөвтэй байна (Зураг 9).

**Зураг 9. ААН-ийн зээлийн эрэлт ба хүлээлт**




- 2024 оны II улиралд нийт салбаруудын зээлийн эрэлт нэмэгдсэн нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарсан байна. Ялангуяа, ХАА-н салбарын зээлийн эрэлт бусад салбаруудтай харьцуулахад нэлээд өндөр байжээ. 2024 оны III улиралд нийт салбаруудын зээлийн эрэлт нэмэгдэх төлөвтэй байна. Ялангуяа, худалдаа, үйлчилгээний салбарт зээлийн эрэлт нэлээд нэмэгдэх хүлээлттэй байна (Хүснэгт 7).

**Хүснэгт 7. ААН-ийн зээлийн эрэлт, салбараар**

Хугацаа	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
2024.II улирлын хүлээлт	0.66	0.65	0.14	0.46	0.12	0.65
2024.II улирлын үр дүн	0.51	0.67	0.36	0.43	0.31	0.43
2024.III улирлын хүлээлт	0.48	0.48	0.17	0.43	0.34	0.50

- 2024 оны II улиралд ААН-ийн зээлийн эрэлт нэмэгдэхэд эргэлтийн болон үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтын зээлийн хүсэлт зээлийн хүсэлт нэмэгдэж, ААН-ийн зээлийн хүүний ерөнхий түвшин буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 10).


**Зураг 10. ААН-ийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс**



### 3.2 Иргэдийн зээлийн эрэлт

- Иргэдийн зээлийн эрэлт 2018 оноос хойш нэлээд хэлбэлзэлтэй байсан бол 2021 оны III улирлаас өнөөг хүртэл өндөр хэвээр байна. 2024 оны II улиралд иргэдийн зээлийн эрэлт бага нэмэгдсэн нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарсан бөгөөд ирэх улиралд мөн эрэлт бага зэрэг нэмэгдэх хүлээлттэй байна (Зураг 11).

**Зураг 11. Иргэдийн зээлийн эрэлт ба хүлээлт**




- 2024 оны II улиралд малчны, автомашины зээлээс бусад бүх төрлийн зээлийн эрэлт нэлээд нэмэгдсэн бөгөөд энэ нь өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарсан байна. 2024 оны III улиралд бүх төрлийн зээлийн эрэлт нэмэгдэх төлөвтэй байна. Ялангуяа, бизнесийн зээлийн эрэлт нэлээд нэмэгдэх хүлээлттэй байна (Хүснэгт 8).

**Хүснэгт 8. Иргэдийн зээлийн эрэлт, зээлийн төрлөөр**

Хугацаа	Нийт зээл	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашины зээл
2024. II улирлын хүлээлт	0.44	0.37	0.59	0.51	0.65	0.77	0.47
2024. II улирлын үр дүн	0.38	0.57	0.19	0.38	0.61	-0.22	-0.03
2024. III улирлын хүлээлт	0.32	0.33	0.27	0.23	0.60	0.22	0.07

- 2024 оны II улиралд иргэдийн зээлийн эрэлт нэмэгдэхэд эдийн засгийн нөхцөл байдлын талаарх хэрэглэгчдийн итгэл нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлжээ (Зураг 12).

**Зураг 12. Иргэдийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс**




#### IV. Зээлийн нийлүүлэлт

##### 4.1 Аж ахуйн нэгжийн зээлийн нийлүүлэлт

- Банкууд ААН-ийн зээлийн нийлүүлэлтээ 2021 оноос өнөөг хүртэл нэмэгдүүлэх хандлагатай хэвээр байна. 2024 оны II улиралд ААН-д нийт 7.01 их наяд төгрөгийн зээл шинээр олгосон нь өмнөх улирлаас 45.4%, өмнөх оны мөн үеэс 52.5%-аар өссөн үзүүлэлт байлаа. 2024 оны III улиралд банкууд ААН-д олгох зээлийн нийлүүлэлтээ нэмэгдүүлэх төлөвтэй байна (Зураг 13).

**Зураг 13. ААН-ийн зээлийн нийлүүлэлтийн төлөв ба шинээр олгосон зээл**



- Банкууд 2024 оны III улиралд бүх салбарт олгох зээлийн нийлүүлэлтээ нэмэгдүүлэх төлөвтэй байна. Ялангуяа, худалдаа, үйлчилгээний салбарт олгох зээлийн нийлүүлэлтээ бусад салбаруудаас илүүтэй нэмэгдүүлэх хандлагатай байна (Хүснэгт 9).


**Хүснэгт 9. ААН-ийн зээлийн нийлүүлэлт, салбараар**

Хугацаа	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
2024.II улирлын хүлээлт	0.66	0.66	-0.03	0.61	0.27	0.66
2024.III улирлын хүлээлт	0.47	0.48	0.32	0.43	0.11	0.59

##### 4.2 Иргэдийн зээлийн нийлүүлэлт

- Банкууд иргэдийн зээлийн нийлүүлэлтээ 2022 оны III улирлыг эс тооцвол 2021 оноос өнөөг хүртэл нэмэгдүүлэх хандлагатай хэвээр байна. Банкууд 2024 оны II улиралд иргэдэд 7.46 их наяд төгрөгийн зээл шинээр олгосон нь өмнөх улирлаас 30.5%-аар өссөн үзүүлэлт болж, өмнөх улирлын хүлээлттэй нийцтэй гарсан байна. Ирэх 2024 оны III улиралд банкууд иргэдэд олгох зээлийн нийлүүлэлтээ нэлээд нэмэгдүүлэх төлөвтэй байна (Зураг 14).

**Зураг 14. Иргэдийн зээлийн нийлүүлэлтийн төлөв ба шинээр олгосон зээл**



\*- Ипотекийн зээлийг эс тооцов.

- Банкууд 2024 оны III улиралд тэтгэврийн зээлээс бусад бүх төрлийн зээлийн нийлүүлэлтээ нэмэгдүүлэх хүлээлттэй байна. Ялангуяа, цалингийн зээлийн нийлүүлэлтээ нэлээд нэмэгдүүлэх хандлагатай байгаа бол тэтгэврийн зээлийн нийлүүлэлтээ хэвээр хадгалах төлөвтэй байна (Хүснэгт 10).

<b>Хүснэгт 10. Иргэдийн зээлийн нийлүүлэлт, зээлийн төрлөөр</b>							
Хугацаа	Нийт зээл	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашинны зээл
2024.II улирлын хүлээлт	0.67	0.46	0.31	0.51	0.65	1.00	0.50
2024.III улирлын хүлээлт	0.52	0.50	0	0.21	0.33	0.44	0.22

**Хавсралт 1. ААН болон иргэдийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс**

<b>Хүснэгт 11. ААН-ийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс, салбараар</b> (2024.II улирал)						
Хүчин зүйлс	Нийт зээл	Хөдөө аж ахуй	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
<b>Эх үүсвэрийн зардал, боломж</b>						
Эх үүсвэрийн өртөг	-0.14	-0.23	0.04	-0.18	0.02	-0.17
Санхүүжилтийн боломж	0.01	-0.02	0.11	0.01	0.04	0
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	0.01	0	0.04	0	0.02	-0.01
<b>Өрсөлдөөн</b>						
Бусад банкуудын өрсөлдөөн	0	0	0	0	0	0.01
Бусад санхүүгийн байгууллагын өрсөлдөөн	0.01	0	0	0	0	-0.01
Санхүүгийн захын өрсөлдөөн	0	0	0	0	0	-0.01
<b>Эдийн засгийн байдал</b>						
Эдийн засгийн өсөлт	-0.18	-0.23	-0.04	-0.18	0.02	-0.16
Инфляц	-0.02	0	0	0	0	-0.01
Валютын ханш	-0.01	0	0	0	0	0
<b>Эрсдэл</b>						
Тухайн салбарын төлөв байдал	-0.19	-0.23	0	-0.18	0	-0.17
Барьцаа хөрөнгийн эрсдэл	-0.17	-0.23	0	-0.17	0	-0.17
Банкны эрсдэл даах чадвар	-0.02	0	0	0	0	-0.01

<b>Хүснэгт 12. Иргэдийн зээлийн шалгуурт нөлөөлөгч хүчин зүйлс, зээлийн төрлөөр</b> (2024.II улирал)							
Хүчин зүйлс	Нийт зээл	Цалин-гийн зээл	Тэтгэв-рийн зээл	Хэрэглэ-ний зээл	Бизнес-ийн зээл	Малчны зээл	Автомашин-ны зээл
<b>Эх үүсвэрийн зардал, боломж</b>							
Эх үүсвэрийн өртөг	0	-0.01	0	-0.01	0.01	0	0.02
Санхүүжилтийн боломж	0	0	0	0	0	0	-0.01
<b>Өрсөлдөөн</b>							
Бусад банкны өрсөлдөөн	-0.28	-0.20	0	-0.15	-0.28	0	0.01
Бусад санхүүгийн байгууллагын өрсөлдөөн	0	-0.01	0	-0.01	0	0	-0.05
<b>Эдийн засгийн байдал</b>							
Эдийн засгийн өсөлт	-0.01	0	0	-0.01	-0.01	0	-0.01
Инфляц	0	0	0	-0.01	0	0	0
Валютын ханш	0	0	0	0	0	0	0
<b>Эрсдэл</b>							
Төлбөрийн чадвар	0.07	-0.01	0.09	-0.01	-0.26	0.50	-0.01
Барьцаа хөрөнгийн эрсдэл	0	-0.01	0.01	-0.01	-0.26	0.44	-0.01
Банкны эрсдэл даах чадвар	-0.01	-0.01	0	-0.01	0	0	-0.01

**Хавсралт 2. ААН болон иргэдийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс**

<b>Хүснэгт 13. ААН-ийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс, салбараар</b> (2024.II улирал)						
Хүчин зүйлс	Нийт зээл	ХАА	Уул уурхай	Боловсруулах үйлдвэр	Барилга	Худалдаа, үйлчилгээ
<b>Санхүүжилтийн хэрэгцээ</b>						
Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт	0.32	0.63	0.24	0.44	0.35	0.43
Эргэлтийн хөрөнгө	0.59	0.41	0.11	0.26	0.55	0.58
Ажиллах хүчин болон тоног төхөөрөмж	0.28	0.25	0.13	0.40	0.28	0.29
Компанийн нэгдэл, бүтцийн өөрчлөлт	0.02	0	0	0	0	0.01
Зээлийн хүүний ерөнхий түвшин	0.33	0.46	0.08	0.35	0.01	0.33
Өрийн дахин санхүүжилт	0.16	0.23	0	0	-0.02	0.16
<b>Бусад санхүүжилтийн хэлбэрүүд</b>						
Дотоод санхүүжилт	0.34	0.45	0.16	0.35	0.41	0.16
Бусад банкуудаас зээлэх	0.16	0.23	0.08	0.17	0.20	0.16
Бусад санхүүгийн байгууллагаас зээлэх	0.17	0.23	0.08	0.17	0.20	0.16
Үнэт цаас, хувьцаа гаргах	-0.01	0	0	0	0	0
Гадаад зах зээлээс санхүүжилт татах	0.01	0	0	0	0	0.01

<b>Хүснэгт 14. Иргэдийн зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс, зээлийн төрлөөр</b> (2024.II улирал)							
Хүчин зүйлс	Нийт зээл	Цалингийн зээл	Тэтгэврийн зээл	Хэрэглээний зээл	Бизнесийн зээл	Малчны зээл	Автомашинны зээл
<b>Санхүүжилтийн хэрэгцээ</b>							
Удаан эдэлгээтэй бараа худалдан авалт	0.09	0.31	0.11	0.23	0.01	-0.22	0.21
Хэрэглэгчдийн итгэл	0.31	0.33	0.11	0.22	0.33	0.44	0.22
Зээлийн хүүний ерөнхий түвшин	0.07	0.05	0.09	0.22	0.01	0.28	0.09
Өрийн дахин санхүүжилт	0.01	0.01	0	0.01	0.01	0	0.01
Үнэт цаас худалдан авалт	0	0	0	0	0	0	0
<b>Бусад санхүүжилтийн хэлбэрүүд</b>							
Өрхийн хуримтлал	0.01	0	0	0.01	0	0	0.01
Бусад банкуудаас зээлэх	0.21	0.20	0.27	0.07	0.26	0.22	0.15
Санхүүжилтийн бусад эх үүсвэр	0	0	0	0	0.01	0	0.01